МЭДЭЭ · 2023 оны 9-р сарын 14

МОНГОЛ УЛС, ХАННС-ЗАЙДЕЛИЙН САНГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ 30 ЖИЛИЙН ОЙ ТОХИОЖ БАЙНА



Дэлхийн 60 гаруй оронд үйл ажиллагаа явуулдаг Ханнс-Зайделийн сан Монгол Улсад 1993 онд байгуулагдаж, эрх зүйн эрдэмтэн, хуульчдын хоорондын харилцааг бэхжүүлэх, эрх зүйн шинэчлэлийг дэмжих чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж эхэлжээ.

Монгол Улс, Ханнс-Зайделийн сангийн хамтын ажиллагааны 30 жилийн ойг тохиолдуулан прокурорын байгууллагын болон тус сангийн төлөөллүүд 2023 оны 9 дүгээр сарын 13-ны өдөр уулзалт, ярилцлага хийлээ.





Тус арга хэмжээнд Улсын ерөнхий прокурорын газрын дэргэдэх Сургалт, судалгааны хүрээлэнгийн захирал, хууль зүйн ухааны доктор Б.Бат-Орших, Гадаад харилцаа, эрх зүйн туслалцааны хэлтсийн дарга Ж.Болорпүрэв, ХБНГУ-ын Вюрцбургийн их сургуулийн тэнхимийн эрхлэгч доктор, профессор Эрик Хилгендорф нар болон бусад албаны хүмүүс оролцлоо.

Уулзалтаар ХБНГУ-ын болон Монгол Улсын эрх зүйн хамтын ажиллагаа, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн ялгаа онцлог, дэвшилтэт талын тухай ярилцаж, цаашдын хамтын ажиллагааны талаар санал солилцлоо.

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/1635